

**БАНК ХООРОНДЫН БЭЛЭН БУС ТӨЛБӨР
ТООЦООНЫ СУДАЛГАА (2007-2011 ЭХНИЙ ХАГАС)**

Энэхүү судалгаагаар банк хоорондын бэлэн бус төлбөр тооцооны сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг нэгтгэж, банк хооронд дамжиж буй мөнгөний тоо, хэмжээ, тэдгээрийн өөрчлөлтийг үзүүлэхийг зорилоо.

Судалгааг дараахь бүтэцтэй хийсэн болно. Үүнд:

- Банк хоорондын нийт гүйлгээний тоо, дүн, өөрчлөлт
- Банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээний тоо, дүн, өөрчлөлт
- Банк хоорондын нэгж гүйлгээний дундаж дүн, түүний өөрчлөлт
- Банк хоорондын төлбөр тооцоонд банкуудын эзлэх хувь хэмжээ.

1. Банк хоорондын нийт гүйлгээний тоо, дүн, өөрчлөлт

Банк хооронд 2007 оноос 2011 оны эхний хагас жилд хийгдсэн нийт гүйлгээний тоо, дүнг нэгтгэж, хүснэгт 1-д үзүүлэв.

**Хүснэгт 1. Банк хоорондын гүйлгээний тоо, дүн,
2007-2011 оны эхний хагас жил**

(мянган ширхэгээр, их наяд төгрөгөөр)

| | 2007 он | | 2008 он | | 2009 он | | 2010 он | | 2011 он | |
|--------------------------------|----------------|-------------|---------------|-------------|----------------|-------------|----------------|-------------|---------------|------------|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| 1-р сар | 109.3 | 0.47 | 143 | 0.83 | 132.8 | 0.59 | 174.1 | 0.6 | 226.3 | 1.2 |
| 2-р сар | 109.8 | 0.43 | 157.2 | 0.79 | 165.6 | 0.52 | 209.5 | 0.88 | 231.8 | 1 |
| 3-р сар | 159.6 | 0.52 | 199.7 | 0.8 | 203.6 | 0.6 | 310.2 | 0.67 | 340.8 | 1.5 |
| I улирал | 378.7 | 1.42 | 499.9 | 2.42 | 502.0 | 1.71 | 693.8 | 2.15 | 798.9 | 3.7 |
| 4-р сар | 160 | 0.55 | 215 | 0.88 | 241 | 0.56 | 310.6 | 0.99 | 335.3 | 1.7 |
| 5-р сар | 170 | 0.68 | 211.1 | 1.04 | 237.9 | 0.58 | 297.3 | 0.98 | 373.5 | 1.7 |
| 6-р сар | 152.8 | 0.61 | 207.5 | 0.83 | 237 | 0.62 | 301.0 | 1.03 | 368.7 | 2 |
| II улирал | 482.8 | 1.84 | 633.6 | 2.75 | 715.9 | 1.76 | 908.9 | 3 | 1077.5 | 5.4 |
| I хагас жилийн нийт дүн | 861.5 | 3.26 | 1133.5 | 5.17 | 1217.9 | 3.48 | 1602.7 | 5.15 | 1876.4 | 9.1 |
| 7-р сар | 120.6 | 0.47 | 157.4 | 0.81 | 194.4 | 0.61 | 237.1 | 0.95 | | |
| 8-р сар | 139.9 | 0.64 | 140.2 | 0.84 | 192.5 | 0.6 | 258 | 1.11 | | |
| 9-р сар | 153.1 | 0.65 | 196.7 | 0.95 | 239.3 | 0.74 | 306.8 | 1.35 | | |
| III улирал | 413.6 | 1.76 | 494.3 | 2.6 | 626.2 | 1.95 | 801.9 | 3.41 | | |
| 10-р сар | 171.7 | 0.67 | 196.3 | 0.9 | 234.5 | 0.72 | 299.8 | 1.2 | | |
| 11-р сар | 163.2 | 0.97 | 170.5 | 0.81 | 225.4 | 0.74 | 299.6 | 1.31 | | |
| 12-р сар | 211.6 | 1.26 | 257.4 | 1.18 | 340.4 | 1.04 | 383.7 | 2.14 | | |
| IV улирал | 546.5 | 2.9 | 624.2 | 2.9 | 800.3 | 2.5 | 983.1 | 4.65 | | |
| Жилийн нийт дүн | 1 821.6 | 7.9 | 2 252 | 10.7 | 2 644.4 | 7.9 | 3 387.7 | 13.2 | | |

Хүснэгт 1-ээс үзэхэд банк хоорондын гүйлгээний тоо 2007 оноос 2011 оны эхний хагас жил хүртэл хугацаанд тогтмол өссөн байхад гүйлгээний дүн 2007-2008 онд өсөлтэй, 2009 онд бууралттай, 2010-2011 онд дахин өссөн байдал харагдаж байна. 2009 онд дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралтай холбоотойгоор манай улсын эдийн засаг, банк, санхүүгийн салбарт хийгдсэн төлбөр тооцооны хэмжээ буурч, энэ нь банк хоорондын гүйлгээний тоо, дүн тухайн онд буурахад нөлөөлсөн байна.

Хамгийн их банк хоорондын гүйлгээ 2010 оны 12 дугаар сард 383.8 мянган ширхэг, 2011 оны 6 дугаар сард 368.7 мянган ширхэг гүйлгээ тус тус хийгдсэн бол хамгийн бага гүйлгээ 2007 оны 1 дүгээр сард 109.3 мянган ширхэг, 2 дугаар сард 109.8 мянган ширхэг гүйлгээ тус тус банк хооронд дамжсан байна.

Гүйлгээний дүнгийн хувьд 2010 оны 12 дугаар сард хамгийн их буюу 2.14 их наяд, 2011 оны 6 дугаар сард 2.0 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн бол 2007 оны 2 дугаар сард хамгийн бага буюу 0.43 их наяд, 1 дүгээр сард 0.47 их наяд төгрөгийн гүйлгээ тус тус хийгджээ.

Хүснэгт 2. Банк хоорондын гүйлгээний тоо, дүнгийн өөрчлөлт 2007-2011 (эхний хагас жил)

(мянган ширхэгээр, их наяд төгрөгөөр)

| | 2007 он | | 2008 он | | 2009 он | | 2010 он | | 2011 он | |
|---------------------------------|--------------|-------------|---------------|-------------|---------------|-------------|---------------|-------------|---------------|------------|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн |
| Хагас жилийн нийт дүн | 861.5 | 3.26 | 1133.5 | 5.17 | 1217.9 | 3.48 | 1600.5 | 5.16 | 1876.4 | 9.1 |
| Өмнөх онтой харьцуулсан: | | | | | | | | | | |
| /+,-/ | | | 272 | 1.91 | 84.4 | -1.69 | 382.6 | 1.68 | 276.1 | 3.94 |
| /%/ | | | 31.6 | 58.6 | 7.5 | -32.7 | 31.4 | 48.3 | 17.2 | 76.4 |
| 2011 онтой харьцуулсан: | | | | | | | | | | |
| /+,-/ | 1014.6 | 5.84 | 742.6 | 3.93 | 658.2 | 5.62 | 276.1 | 3.94 | | |
| /%/ | 117.8 | 179.1 | 65.5 | 76 | 54 | 161.5 | 17.2 | 76.4 | | |


Хүснэгт 2-т үзүүлснээр гүйлгээний тоо хагас жилийн байдлаар 2008 онд 272 мянган ширхэг буюу 32 хувь, 2009 онд 84 мянган ширхэг буюу 7.5 хувь, 2010 онд 383 мянган ширхэг буюу 31 хувь, 2011 онд 276 мянган ширхэг буюу 17 хувиар тус тус нэмэгджээ. 2011 оны эхний хагас жилийн гүйлгээний тоог 2007 оны эхний хагас жилтэй харьцуулахад 1 сая ширхэг буюу 117 хувиар, харин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 276 мянгаар буюу 17 хувиар тус тус өсчээ. 2009 оны өсөлт бусад үетэй харьцуулахад илт бага байна.

Гүйлгээний дүнг хагас жилийн байдлаар авч үзвэл 2008 онд 1.9 их наяд төгрөг буюу 59 хувиар өсч, 2009 онд 1.7 их наяд төгрөг буюу 33 хувиар буурч, 2010 онд 1.7 их наяд төгрөг буюу 48 хувиар, 2011 онд 3.9 их наяд төгрөг буюу 76 хувиар тус тус өсчээ. 2011 оны эхний хагас жилийн гүйлгээний дүнг 2007 онтой харьцуулахад 5.8 их наяд төгрөг, харин өнгөрсөн оны тухайн үетэй харьцуулахад 3.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь 2007 оны хагас жилээс 2,8 дахин, 2010 оны мөн үеэс 0.7 дахин их байна.

Банк хоорондын 2007 оноос 2011 оны эхний хагас жилд хийсэн гүйлгээний тоо, дүнг зураг 1-т үзүүлэв.

**Зураг 1. Банк хоорондын гүйлгээний тоо, дүн
2007-2011 оны эхний хагас жилийн байдлаар (улирлаар)**

(мянган ширхэгээр, тэрбум төгрөгөөр)



Санхүүгийн хямралтай байсан 2009 оноос бусад үед банк хоорондын гүйлгээний үзүүлэлтүүд жилээс жилд өсөн нэмэгдэж байсныг зураг 1-ээс харж болно.


Банк хоорондын гүйлгээний тоо, дүн жилийн туршид өсөлт, бууралттай хэлбэлзэж байдаг. Сүүлийн 5 жилийн энэхүү зургаас үзэхэд гүйлгээний тоо, дүн 1 ба 3 дугаар улиралд буурч, 2 ба 4 дүгээр улиралд өсдөг хандлага ажиглагдаж байгаа нь улирлын нөлөө буюу санхүүгийн жилийн эцсийн болон хагас жилийн төлбөр тооцоо нэмэгддэгтэй холбоотой юм.

Банк хоорондын гүйлгээний дүнг Зураг 2-т сар бүрээр үзүүлэв. Судалгаанд хамрагдсан 5 жилийн зургаас үзэхэд 2007 оны банк хоорондын гүйлгээний дүн хамгийн бага, 2008 онд банк хоорондын гүйлгээний дүн 10 сар хүртэл өсөлттэй байсан боловч 11 дүгээр сараас эхлэн буурч, өмнөх оны мөн үеэс доогуур болж, улмаар 2009 онд банк хоорондын гүйлгээний дүн үргэлжлэн буурч, 2007 оны түвшинд ойртож, зарим үед түүнээс ч доогуур байжээ.

2010 онд банк хоорондын гүйлгээний дүн нэмэгдэж эхэлсэн бөгөөд 2011 оны хагас жилийн үзүүлэлтийг өмнөх жилүүдийн мөн үетэй харьцуулахад 2007 ба 2009 оноос 3 дахин, 2008 оноос бараг 2 дахин, 2010 оны мөн үеэс 1.8 дахин их болжээ. 2011 оны хагас жилийн байдлаарх банк хоорондын гүйлгээний дүн 2010 оны жилийн эцсийн дүнтэй ойролцоо түвшинд хүрсэн байна.

**Зураг 2. Банк хоорондын гүйлгээний дүн
2007-2011 оны эхний хагас жилийн байдлаар**

(сараар, тэрбум төгрөгөөр)



2. Банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээний тоо, дүн

Монголбанкны журмаар банк хоорондын бага дүнтэй гүйлгээний дүнгийн дээд хязгаар 1,000,000.00 (нэг сая) төгрөг бөгөөд түүнээс дээш дүнтэй гүйлгээг банк хоорондын их дүнтэй гүйлгээ гэж үздэг. Банк хоорондын бага дүнтэй гүйлгээ болон картын гүйлгээг Монголбанкны Төлбөр тооцооны төвөөр, банк хоорондын их дүнтэй гүйлгээг Монголбанкны Банксүлжээ (RTGS) системээр дамжуулан гүйцэтгэж байна.

Банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээний тоо, дүнг 2007-2011 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэж хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2-оос үзэхэд банк хооронд 2011 оны эхний хагас жилийн өссөн дүнгээр нийт 1 876.4 мянган ширхэг гүйлгээ хийгдсэнээс 84 хувь буюу 1 574.3 мянган ширхэгийг бага дүнтэй гүйлгээ, 16 хувь буюу 302.1 мянган ширхэг гүйлгээг их дүнтэй гүйлгээ эзэлж байна. Банк хооронд нийт 9.1 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэнээс 97.8 хувь буюу 8.9 их наяд төгрөгийг их дүнтэй гүйлгээ, 2.2 хувь буюу 0.2 их наяд төгрөгийг бага дүнтэй гүйлгээ тус тус эзэлсэн байна. Энэ нь банк хооронд хийгдэж буй гүйлгээний тооны ихэнх хувийг бага дүнтэй гүйлгээ эзэлдэг бол гүйлгээний дүнгийн ихэнх хувийг их дүнтэй гүйлгээ эзэлдэг гэдгийг харуулж байна.

Ийм харьцаа 2007 оноос 2011 оны эхний хагас жилийн туршид хадгалагдаж ирснийг мөн хүснэгтээс харж болно. Их, бага дүнтэй гүйлгээний тооны харьцаа 2007 онд 83:17, 2008 онд 82:18, 2009-2010 онд 84:15 байсан бол их, бага дүнтэй гүйлгээний дүнгийн харьцаа 2007 онд 97:3, 2008 онд 98:2, 2009 онд 96:4, 2010 онд мөн 97:3 тус тус байжээ.

**Хүснэгт 2. Банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээний тоо, дүн
2007-2011 оны эхний хагас жилийн байдлаар (улирлаар)**


(мянган ширхэгээр, их наяд төгрөгөөр)

| | 2007 он | | 2008 он | | | | 2009 он | | | | 2010 он | | | | 2011 он | | | |
|-------------------|----------------|-------------|--------------|-----------|--------------|-------------|---------------|------------|-------------|------------|---------------|-----------|--------------|-----------|---------------|-----------|-------------|-----------|
| | тоо | дүн | тоо | Δ% | дүн | Δ% | тоо | Δ% | дүн | Δ% | тоо | Δ% | дүн | Δ% | тоо | Δ% | дүн | Δ% |
| I улирал | 378.7 | 1.42 | 499.9 | 32 | 2.42 | 70.4 | 502 | 0.4 | 1.71 | -29 | 693.8 | 38 | 2.15 | 26 | 798.9 | 15 | 3.7 | 72 |
| Бага дүнтэй | 319.2 | 0.04 | 416.1 | 30 | 0.06 | 50 | 421.3 | 1 | 0.06 | 20 | 596.2 | 41 | 0.07 | 17 | 669.2 | 12 | 0.1 | 43 |
| Их дүнтэй | 59.5 | 1.38 | 83.8 | 41 | 2.36 | 71 | 80.7 | -4 | 1.65 | -30 | 97.6 | 21 | 2.08 | 26 | 129.7 | 33 | 3.6 | 73 |
| II улирал | 482.8 | 1.84 | 633.6 | 31 | 2.75 | 49 | 715.9 | 13 | 1.76 | -36 | 908.9 | 27 | 3 | 70 | 1077.5 | 18 | 5.4 | 80 |
| Бага дүнтэй | 406.6 | 0.05 | 530.3 | 30 | 0.07 | 40 | 614.3 | 16 | 0.07 | - | 782.2 | 27 | 0.1 | 43 | 905.1 | 16 | 0.1 | - |
| Их дүнтэй | 76.2 | 1.79 | 103.3 | 36 | 2.68 | 50 | 101.6 | -2 | 1.69 | -37 | 126.7 | 25 | 2.9 | 72 | 172.4 | 36 | 5.3 | 83 |
| III улирал | 413.6 | 1.76 | 494.3 | 20 | 2.59 | 47 | 626.2 | 27 | 1.95 | -24 | 801.9 | 28 | 3.41 | 74 | | | | |
| Бага дүнтэй | 341.8 | 0.05 | 396.9 | 16 | 0.06 | 20 | 526.3 | 33 | 0.07 | 17 | 675.8 | 28 | 0.08 | 14 | | | | |
| Их дүнтэй | 71.8 | 1.71 | 97.4 | 36 | 2.53 | 48 | 99.9 | 3 | 1.88 | -26 | 126.1 | 26 | 3.33 | 77 | | | | |
| IV улирал | 546.5 | 2.90 | 624.2 | 14 | 2.89 | -0.4 | 800.3 | 28 | 2.5 | -14 | 983.1 | 23 | 4.65 | 86 | | | | |
| Бага дүнтэй | 443.6 | 0.06 | 501.6 | 13 | 0.08 | 33 | 670.3 | 34 | 0.09 | 12 | 815.5 | 22 | 0.11 | 22 | | | | |
| Их дүнтэй | 102.9 | 2.84 | 122.6 | 19 | 2.81 | -1 | 130 | 6 | 2.41 | -14 | 167.6 | 29 | 4.54 | 88 | | | | |
| Нийт | 1 821.6 | 7.92 | 2 252 | 24 | 10.66 | 34 | 2644.4 | 17 | 7.92 | -26 | 3387.7 | 28 | 13.21 | 67 | 1876.4 | | 9.1 | |
| Бага дүнтэй | 1511.2 | 0.20 | 1844.9 | | 0.27 | | 2232.2 | | 0.29 | | 2869.7 | | 0.36 | | 1574.3 | | 0.2 | |
| <i>эзлэх хувь</i> | <i>83</i> | <i>3</i> | <i>82</i> | | <i>2</i> | | <i>84</i> | | <i>4</i> | | <i>85</i> | | <i>3</i> | | <i>83.9</i> | | <i>2.2</i> | |
| Их дүнтэй | 310.4 | 7.72 | 407.1 | | 10.39 | | 412.2 | | 7.63 | | 518 | | 12.85 | | 302.1 | | 8.9 | |
| <i>эзлэх хувь</i> | <i>17</i> | <i>97</i> | <i>18</i> | | <i>98</i> | | <i>16</i> | | <i>96</i> | | <i>15</i> | | <i>97</i> | | <i>16.1</i> | | <i>97.8</i> | |

2008-2011 оны эхний хагас жилийн байдлаарх банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээний тооны өөрчлөлтийг зураг 3-т, дүнгийн өөрчлөлтийг зураг 4-т тус тус үзүүлэв.

**Зураг 3. Банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээний тоо
2008-2011 оны эхний хагас жилийн байдлаар**


(улирлаар, мянган ширхэгээр)



Зураг 3-аас үзэхэд 2011 оны эхний хагас жилийн байдлаар бага дүнтэй гүйлгээний тоо их дүнтэй гүйлгээний тооноос 5,2 дахин их байна. Өмнөх жилүүдэд ч бага дүнтэй гүйлгээний тоо илт давамгайлж байсан бөгөөд бага дүнтэй гүйлгээний тоо 2 ба 4 дүгээр улиралд өсөөд, 1 ба 3 дугаар улиралд буурдаг байна.

**Зураг 4. Банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээний дүн
2008-2011 оны эхний хагас жилийн байдлаар**

(улирлаар, их наяд төгрөгөөр)



Дээрх зургаас үзэхэд бага дүнтэй гүйлгээний дүн нь банк хоорондын гүйлгээний дүнгийн үлэмж бага хувийг эзэлдэг байна. 2008 онд их дүнтэй гүйлгээний дүн харьцангуй тогтмол 2.3-2.8 их наяд төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан бол 2009 оны эхэнд их дүнтэй гүйлгээний дүн 1.6 их наяд төгрөг хүртэл огцом буурсан ба жилийн турш аажмаар өсч, оны эцэст 2.3 их наяд орчим төгрөг буюу 2008 оны эхний үеийн түвшинд хүрчээ. 2010 оны 4 дүгээр улиралд их дүнтэй гүйлгээний дүн 4.5 их наяд төгрөг, 2011 оны 2 дугаар улиралд 5.3 их наяд төгрөг хүртэл тус тус өссөн байна.

3. Банк хоорондын нэгж гүйлгээний дундаж дүн


Банк хоорондын нэгж гүйлгээний дундаж дүнг 2008-2011 оны үзүүлэлтээр дараах байдлаар авч үзье.

Үүнд:

- Банк хоорондын бага дүнтэй нэгж гүйлгээний дундаж дүн
- Банк хоорондын их дүнтэй нэгж гүйлгээний дундаж дүн

**Зураг 5а. Бага дүнтэй нэгж гүйлгээний дундаж дүн
2008-2011 оны эхний хагас жилийн байдлаар**


(улирлаар, мянган төгрөгөөр)



Зураг 5а-аас харахад 2008 онд бага дүнтэй нэгж гүйлгээний дундаж дүн 150-160 мянган төгрөг, 2009 онд 120-140 мянган төгрөг, 2010 онд 120-140 мянган төгрөг, 2011 оны эхний хагас жилийн байдлаар 110.5-149.5 мянган төгрөгийн хооронд тус тус хэлбэлзэж байжээ. 2011 оны эхний хагас жилийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 дүгээр улиралд 30 орчим мянган төгрөгөөр өссөн, 2 дугаар улиралд 5 орчим мянган төгрөгөөр буурсан байна.

**Зураг 5б. Их дүнтэй нэгж гүйлгээний дундаж дүн
2008-2011 оны эхний хагас жилийн байдлаар**

(улирлаар, мянган төгрөгөөр)



Зураг 5б-ээс харахад их дүнтэй нэгж гүйлгээний дундаж дүн 2008 онд 24-26 сая төгрөг, 2009 онд 16-19 сая төгрөг, 2010 онд 21-26 сая төгрөг, 2011 оны эхний хагас жилд 28-31 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байжээ. 2011 оны эхний хагас жилийг өнгөрсөн оны эхний хагас жилийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад 1 дүгээр улиралд 6.4 сая төгрөгөөр, 2 дугаар улиралд 7.7 сая төгрөгөөр тус тус өссөн хандлагатай байна.

ДУГНЭЛТ

Эдийн засаг өсч, санхүүгийн системийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр банк хоорондын гүйлгээний тоо, дүн эрс нэмэгдснийг энэхүү судалгааны 2010-2011 оны үзүүлэлтээс харж болно. Судалгаанд хамрагдсан сүүлийн 5 жилийн байдлыг авч үзэхэд банк хоорондын гүйлгээний тоо, дүн 2007-2008 онд өсч, 2009 онд буурч байжээ.

1. 2011 оны эхний хагас жилийн гүйлгээний тоог 2007 оны эхний хагас жилтэй харьцуулахад 1 сая ширхэг буюу 117 хувиар, харин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 276 мянгаар буюу 17 хувиар тус тус өсчээ.

2. 2011 оны эхний хагас жилийн гүйлгээний дүнг 2007 онтой харьцуулахад 5.8 их наяд төгрөг, харин өнгөрсөн оны тухайн үетэй харьцуулахад 3.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь 2007 оны хагас жилээс 2.8 дахин, 2010 оны мөн үеэс 0.7 дахин их байна.

3. Банк хоорондын их, бага дүнтэй гүйлгээний харьцаа сүүлийн 5 жилд бараг жигд хадгалагджээ. Их дүнтэй гүйлгээ нийт гүйлгээний дүнгийн 96-98 хувь, нийт гүйлгээний тооны 16-18 хувийг эзэлдэг бол бага дүнтэй гүйлгээ үүний эсрэг, нийт гүйлгээний тооны 82-84 хувь, гүйлгээний дүнгийн 2-4 хувийг тус тус эзэлдэг байна.

4. Банк хоорондын нэгж гүйлгээний дундаж дүн сүүлийн 5 жилд бага зэрэг хэлбэлзэж байжээ. 2008 онд бага дүнтэй нэгж гүйлгээний дундаж дүн 150-160 мянган төгрөг байсан бол 2009 онд 120-140 мянган төгрөг болж буураад, 2011 онд 110.5-149.5 мянган төгрөгт хүрч дахин нэмэгджээ. Их дүнтэй нэгж гүйлгээний дундаж дүн 2008 онд 24-26 сая төгрөг байсан бол 2009 онд 16-19 сая төгрөг хүртэл буурсан боловч 2011 оны эхний хагас жилд 28-31 сая төгрөгт хүрч нэмэгдсэн байна.

ТӨЛБӨР ТООЦОО, БҮРТГЭЛИЙН ГАЗАР

Төлбөрийн бодлого, зохицуулалтын хэлтэс